



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн талаар баримтлах бодлого”-ыг батлах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.3, 4.9.1 дэх заалтууд; ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрмийн 3.2.1, 7.3, 7.5 дахь заалтууд; Эрдмийн зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн талаар баримтлах бодлого” –ыг Эрдмийн зөвлөлийн гишүүдийн саналыг тусган хавсралтын дагуу баталсугай.
2. Энэхүү бодлогын баримт бичгийг 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ШУТИС-ийн хэмжээнд мөрдөж эхэлсүгэй.
3. “ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлыг их сургуулийн жил бүрийн ажлын төлөвлөгөө, санхүүгийн төсөвт тусгаж, гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллахыг их сургуулийн бүрэлдэхүүн сургуулиуд, хүрээлэнгүүд болон бүтцийн нэгжийн захирал, дарга нарт үүрэг болгосугай.
4. “ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн талаар баримтлах бодлого”-ыг таниулах, сурталчилах үйл ажиллагааг зохион байгуулахыг Эрдэм шинжилгээ инновацийн газар, Технологи дамжуулах төв, бүрэлдэхүүн сургуулиудад даалгасугай.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ОЧИРБАТ

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИНГИЙН ДАРГА

Т.НАМНАН

ШУТИС-ийн ЭЗ-ийн хуралдааны 2020 оны
08-р сарын 28-ны өдрийн 08 тоот
ТОГТООЛЫН ХАВСРАЛТ



	ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО ШУТИС-ЭШ-Б001	Эхний хэвлэлт	2020.04.28
		Өөрчилсөн огноо	-
		Өөрчлөлтийн дугаар	0

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Боловсруулсан:

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИЙН ГАЗАР

Хянасан:

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ХАМТЫН АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ

ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЛБА

Дэмжсэн:

ШУТИС-ИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-ИЙН ЗАХИРАЛ

ШУТИС-ийн ЭЗ-ийн хуралдааны 2020 оны
07-р сарын 28-ны өдрийн 12 тоот
тогтоолын хавсралт



АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	3
ТАВ. ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	4
ЗУРГАА. ЗОРИЛГО, ЗОРИЛТ	5
ДОЛОО. ЗАРЧИМ	5
НАЙМ. ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД	6
ЕС. ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	8
АРАВ. БУСАД	9



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 ШУТИС-2030 Стратеги төлөвлөгөөнд тусгасан урт хугацааны үндсэн зорилго “2030 онд Дэлхийн шилдэг 1000 их сургуулийн нэг болох”-ын хүрээнд (1) багш, судлаач, оюутны шинэ мэдлэг, бүтээл туурвих үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, (2) судлаачдын ур чадвар, судалгааны чадавхыг бэхжүүлэх, (3) оюуны өмчийн эрхийн хамгаалалт, хадгалалтын механизмыг боловсронгуй болгох шаардлага урган гарч байна;
- 1.2 Их сургуульд бий болж буй судалгааны үр дүнг нийгмийн хүлээлт, зах зээлийн шаардлагад нийцүүлэх үүднээс тэргүүлэх чиглэлээ тодорхойлж, эдийн засгийн хөшүүрэг, эрх зүйн орчин бүрдүүлэх, төр хувийн хэвшил, их сургууль-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэдлэг, технологи дамжуулах, лицензийн гэрээ байгуулах зэрэг асуудлуудад нэгдсэн бодлогоор хандах шаардлагатай байна.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Бодлого нь ШУТИС-ийн эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааг хамарна;
- 2.2 Түүнчлэн их сургуулийн эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаанд оролцогч болон сонирхогч бүх талуудад хамаарна.

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 3.1 Төрөөс ШУТ-ийн талаар баримтлах бодлого (2014-2025);
- 3.2 Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого (2018-2025);
- 3.3 Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2019-2023);
- 3.4 “ШУТИС-2030 Стратеги төлөвлөгөө” зэрэг нь энэхүү бодлогын эрх зүйн үндэслэл болно.

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1 **Судлаач** – Их сургуулийн харьяалал бүхий, эрдэм шинжилгээ, хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэгч эрдэмтэн, багш, ажилтан, оюутнууд;
- 4.2 **Академик эрх чөлөө** – Хичээл заах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх эрх чөлөөний нийлбэр ба өөрийн удирдлага, хугацаагүй гэсэн туслах элементүүдээр дэмжигдэж байдаг цогц эрх (Бадарч, Д. нар, 2018);
- 4.3 **Их сургууль-үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа** – Их сургуулийн хэмжээнд бүтээгдэх оюуны бүтээл, холбогдох эрдэм шинжилгээний бүхий л ажлуудыг зах зээлд нийцүүлэх, үйлдвэрт нэвтрүүлэх зорилгоор хамтарч ажиллах үйл ажиллагаа;
- 4.4 **Эрдэм шинжилгээ, судалгааны ажил** - Янз бүрийн хүчин зүйл (фактор) - ээс хамааран судалж байгаа зүйл (объект) -ийн өөрчлөгдөх шинэ үзэгдэл, зүй тогтлыг илрүүлж тэрхүү зүй тогтлыг цаашид амьдрал практикт ашиглаж болох зорилго бүхий үйл ажиллагаа (Авдай, Ч., Энхтуяа, Д., 2007);

ШУТИС-ийн ЭЗ-ийн хуралдааны 2020 оны
07-р сарын 28-ны өдрийн 08 тоот
тогтоолын хавсралт



- 4.5 Оюуны өмч** – Судалгаа шинжилгээний ажлын үр дүнд бий болох зохиогчийн эрх, аж үйлдвэрийн салбаруудад хамаарах өмч. Тэдгээрийг хамгаалж, хадгалж, дангаар, бусдад, эсвэл хамтаар ашиглах боломж олгож болно;
- 4.6 Инновацийн үйл ажиллагаа** - Шинэ санаа, шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, технологи, ажил, үйлчилгээг бий болгож зах зээлд нийлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ (Инновацийн тухай хууль 3.1.3);
- 4.7 Инновацийн кластер** - Шинжлэх ухаан, боловсрол - инновацийн жижиг, дунд бизнес - том бизнесийн хоршсон хэлхээ (Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, БСШУСЯ 2006);
- 4.8 Технологи дамжуулалт** – Технологи эзэмшигч өөрийн технологийг ашиглах эрхийг бусад иргэн, хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр шилжүүлэх үйл ажиллагаа;
- 4.9 Лицензийн гэрээ** - Оюуны бүтээлийг ашиглах эрхийг олгох эсвэл олж авах гэрээ.

ТАВ. ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

5.1 Нийт багш, судлаач, ажилтан, оюутнууд

- 5.1.1 ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн талаар баримтлах бодлого, зорилго, зорилтууд, зарчмуудыг ойлгож, хэрэгжүүлж ажиллана;
- 5.1.2 Хувь хүний ур чадвар, мэдлэг боловсролыг ямагт дээшлүүлж, шинийг эрэлхийлнэ;

5.2 Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн нэгж

- 5.2.1 Энэхүү бодлогыг хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, төлөвлөгөө болон холбогдох журам, зааврыг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна;
- 5.2.2 Бодлогын хэрэгжилт, холбогдох тайлангийн дүн мэдээ гаргах, олон нийтэд мэдээлэх, таниулан сурталчлах ажлыг хариуцна;

5.3 Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн удирдах албан тушаалтан

- 5.3.1 Холбогдох тайланг жил бүр хянаж, дүгнэж, Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөлд тайлагнана;
- 5.3.2 Багш, судлаач, ажилтан, оюутнууд нь эрдэм шинжилгээ, судалгаа, инновацид харшлах үйл ажиллагаа явуулан ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд холбогдох шатанд уламжилж, шийдвэрлүүлнэ;

5.4 Сургалт, оюутны асуудал эрхэлсэн удирдах албан тушаалтан

- 5.4.1 Сургалтыг эрдэм, шинжилгээ инновацитай хэрхэн уялдуулсан, дэмжсэн тухай тайланг жил бүр хянаж, дүгнэж, Сургалт, оюутны хөгжлийн дэд зөвлөлд тайлагнана;

5.5 Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөл

ШУТИС-ийн ЭЗ-ийн хуралдааны 2022 оны
07-р сарын 22-ны өдрийн 22
тогтоолын хавсралт



5.5.1 Тус бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, санал, зөвлөмж гаргах чиг үүрэг хүлээнэ;

5.6 ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл

5.6.1 Эрдэм шинжилгээ, инновацийн талаар баримтлах бодлогыг хэлэлцэх, батлах үүрэг хүлээнэ;

5.7 Чанарын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж

5.7.1 Энэхүү бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ;

5.7.2 Хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна;

5.7.3 Үнэлгээний тайланг ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ;

5.8 Эрдэм шинжилгээ, инновацийн талаар баримтлах бодлогын оролцогч талууд нь уг бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах, өөрчлөх, сайжруулах, үр дүнг гаргаж, үнэлэх, тайлагнах талаар санал гаргах эрхтэй.

ЗУРГАА. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

6.1 Бодлогын зорилго нь “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө”-нд заасан (II) Судалгааны төгөлдөршил болон (III) Инноваци, технологи арилжаалалт” тэргүүлэх чиглэлүүдийг иш үндэс болгож, их сургуулийн судалгааны үр өгөөжийг дээшлүүлэх, оюуны өмч бүтээх, хамгаалах, ашиглах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, технологи дамжуулах үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангахад чиглэгдэнэ;

6.2 Бодлогын зорилтууд

6.2.1 Монгол улс, олон улсын хэмжээнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхүйц судалгааг дэмжиж, хөгжүүлнэ;

6.2.2 Технологи-үнэ цэнийг бүтээгч инновацийн кластер болж хөгжихөд түлхэц үзүүлнэ.

ДОЛОО. ЗАРЧИМ

7.1 Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, бодлогын хүрээнд байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, стратегийн тэргүүлэх чиглэлүүд, чанарын менежментэд нийцэж ажиллах;

7.2 Мэргэшсэн, өндөр чадамж бүхий, авьяаслаг судлаачдыг дэмжих;

7.3 Бодлогын үйл ажиллагаанд нээлттэй, ил тод, тэгш байдал, ёс зүйн хэм хэмжээг баримтлах;

7.4 Багш, судлаач, ажилтан, суралцагч, ажил олгогчдын хүлээлтэд нийцсэн эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаа явуулах;

7.5 Хамтрагч их сургууль, эрдэм шинжилгээний бусад байгууллага, төр, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодтой идэвхтэй хамтран ажиллах, харилцан ашигтай түншлэх;

7.6 Их сургуулийн хэмжээнд бүтээгдсэн эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;

ШУТИС-ийн ЭЗ-ийн хуралдааны 2022 оны
07-р сарын 22-ны өдрийн 02-тоот
тогтоолын хавсралт



- 7.7 Судлаачдыг эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаа амжилттай явуулахад хөхиүлэн дэмжиж, үр өгөөж өндөр, шилдэг бүтээлийг зохиогчийн хамт урамшуулах;
- 7.8 Бодлогын хэрэгжилтийн хүрээнд нийтийн боловсролыг дээшлүүлэх.

НАЙМ. ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

- 8.1 “Монгол Улс, олон улсын хэмжээнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхүйц судалгааг хөгжүүлэх” зорилтын хүрээнд:
- 8.1.1 Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн судлаачдыг их сургуулийн судалгаа хөгжүүлэлтэд татан ажиллуулна. Үүнд:
- 8.1.1.1 Их сургуулийн чадварлаг багш, шилдэг судлаачдыг бэлтгэх, ажилд шалгаруулж авах /тенюр/ үр дүнтэй аргыг нэвтрүүлнэ;
- 8.1.1.2 Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, залуу судлаачдыг судалгааны ажилд татан оролцуулах, гадаад, дотоодын нэр хүндтэй эрдэмтдийг урьж ажиллуулна;
- 8.1.1.3 Багш судлаачидтай судалгааны ажлын үр дүнгийн гэрээ байгуулж ажиллана /багш бүрийн тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгуулах/;
- 8.1.1.4 Судалгааны ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээ, урамшууллын оновчтой системийг тууштай хэрэгжүүлнэ;
- 8.1.2 Дэлхийн шилдэг их сургуулийн жишигт нийцүүлэн судалгаа боловсруулалтын ажлын таатай орчинг бүрдүүлнэ. Үүнд:
- 8.1.2.1 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх, оюуны шинэ бүтээл туурвих, академик эрх чөлөөг олгох эрх зүйн орчинг боловсронгуй болгоно;
- 8.1.2.2 ШУТИС-ийн хэмжээнд хэрэгжих Ахисан түвшний сургалт, судалгааны уялдаа холбоог төгөлдөржүүлж, авьяаслаг, чадварлаг судлаачдын төвлөрлийг бий болгоно;
- 8.1.2.3 Магадлан итгэмжлэгдсэн салбар дундын судалгааны төв, хүрээлэн, лабораториудыг хөгжүүлж, ашиглалтыг сайжруулж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ;
- 8.1.2.4 Төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээнд судалгааны санхүүжилтийг нэмэгдүүлж, багш судлаачдыг төсөл, хөтөлбөрт өргөнөөр хамруулж, санхүүжилт, тэтгэлэг олгох механизмыг боловсронгуй болгоно;
- 8.1.2.5 Багш судлаачид (зочин судлаач, докторын дараах), ахисан түвшний оюутнуудад бүтэн цагаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах нөхцөл (сургалтын ачаалал, судалгааны өрөө, техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж гэх мэт), боломжийг бүрдүүлнэ;
- 8.1.3 Улс орны хөгжилд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх салбар дундын судалгааг эрхлэн явуулна. Үүнд:
- 8.1.3.1 Их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны төв, хүрээлэнг түшиглэн “нэгдэл-нягтрал буюу салбар дундын судалгааны талбар, сүлжээ” бий болгох, тэргүүлэх судалгааг хөгжүүлнэ;

ШУТИС-ийн ЭЗ-ийн хуралдааны 2020 оны
08-р сарын 28-ны өдрийн 02-тоот
тогтоолын хавсралт



- 8.1.3.2 Судалгааны тэргүүлэх чиглэлүүдийг аж үйлдвэрийн 4-р хувьсгалын хэрэгцээнд нийцүүлэн тодорхойлж, платформ хөгжүүлж, холбогдох судалгааг дэмжинэ;
- 8.1.3.3 Их сургууль-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлж, захиалгат төслийг нэмэгдүүлж, хэрэгжилт, үр өгөөжийг сайжруулна;
- 8.1.3.4 Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих ажлууд, үзэсгэлэн, хурал, сургалт, семинар, уралдаан тэмцээн зэргийн чанар, үр өгөөжийг нэмэгдүүлнэ;
- 8.1.4 Их сургуулийн оюуны өмчийн хадгалалт, хамгаалалтын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож судалгаа, бүтээлийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэнэ. Үүнд:
 - 8.1.4.1 Оюуны өмчийн хадгалалт, хамгаалалт, мэдээллийн цахим системийг бий болгоно;
 - 8.1.4.2 Бүтээлийн хуулбарлалтаас хамгаалсан шалгах, илрүүлэх программын системийг нэвтрүүлж, хэвшүүлнэ;
 - 8.1.4.3 Эрдэм шинжилгээний бүтээлийг олон улсад хэвлүүлэх үйл явцыг идэвхжүүлнэ;
 - 8.1.4.4 Профессор, багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл болон сэтгүүлүүдийн чанарыг дээшлүүлж, судлаачдад олон улсын түвшний шалгуураар Монгол хэл дээр хэвлэх боломжийг бүрдүүлнэ;
 - 8.1.4.5 Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын соёл, ёс зүйг төлөвшүүлэн хөгжүүлнэ;
 - 8.1.4.6 Олон улсад бүртгэлтэй сэтгүүлүүдийн хэвлэлтийн чанарыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;
- 8.2 “ШУТИС-ийг технологи-үнэ цэнийг бүтээгч инновацийн кластер болж хөгжихөд түлхэц үзүүлэх” зорилтын хүрээнд:
 - 8.2.1 Инновацийн соёл, энтрепренёр сэтгэлгээг төлөвшүүлж, судалгааны нөөцийн ашиглалтыг сайжруулна. Үүнд:
 - 8.2.1.1 Их сургуулийн зүгээс багш судлаачдын судалгааны үр дүн, оюуны өмчийг үнэлэх, урамшуулах тогтолцоог бүрдүүлж, мөрдөн ажиллана;
 - 8.2.1.2 Багш судлаачдад оюуны өмчийг задлах, ашиглах, технологи дамжуулах арга зүйг нэвтрүүлж, соёл хандлагыг төлөвшүүлнэ;
 - 8.2.1.3 Профессор, багш судлаач, суралцагчдын бизнес сэтгэлгээг хөгжүүлэх, тэдэнд энтрепренёр боловсрол олгох, соёл төлөвшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ;
 - 8.2.1.4 Шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийн орчин үеийн тэргүүлэх чиглэлээр мэргэшсэн чадварлаг инноваторуудыг төвлөрүүлнэ;
 - 8.2.1.5 Судалгааны үр дүнг дэвшилтэт болон шинэ технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, нэвтрүүлэх, нутагшуулахад чиглүүлнэ;
 - 8.2.2 Инновацийн дэд бүтэц, экосистемийг бүрдүүлнэ. Үүнд:
 - 8.2.2.1 Инновацийн үйл ажиллагааг зохицуулах, дэмжих, холбогдох дүрэм журмыг боловсронгуй болгоно;

ШУТИС-ийн ЭЗ-ийн хуралдааны 2020 оны
07 сарын 28-ны өдрийн 28 тоот
ТОГТООЛЫН ХАВСРАЛТ



- 8.2.2.2 Технологи дамжуулалт, инкубатор, гарааны бизнесийн хамтын оффис зэрэг инновацийн үйл ажиллагааг дэмжих дэд бүтцийн нэгжүүдийг байгуулж, уян хатан ажиллах нөхцөл боломжоор хангана;
- 8.2.2.3 Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, инновацийн үйл ажиллагааг тасралтгүй дэмжих венч хөрөнгө оруулалтын санг холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн байгуулж, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ;
- 8.2.2.4 Инновацийн түншлэл, гадаад, дотоод хамтын ажиллагаа /их сургууль болон төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоод хоорондын/-г, хөгжүүлнэ;
- 8.2.3 Оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, технологи, ажил үйлчилгээг бий болгоно. Үүнд:
- 8.2.3.1 Их сургуулийн судалгааны үр дүн, оюуны өмчийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн хөтөлбөр, үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлнэ;
- 8.2.3.2 Эдийн засгийн үр ашиг өгөх оюуны бүтээлийг худалдах, технологи дамжуулах, лицензийн гэрээ байгуулах, оюуны өмчид тулгуурласан гарааны компаниуд байгуулахыг дэмжин ажиллана;
- 8.2.3.3 Гадаадын өндөр технологийг нутагшуулан улмаар мэдлэг шингээж, импортыг орлоход чиглэсэн судалгааг хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно;
- 8.2.3.4 Оюуны өмчийн роялти, лицензийн гэрээ, гарааны компаний ногдол ашгаас олох орлогыг нэмэгдүүлнэ;
- 8.2.3.5 Технологи арилжаалалт, инновацийн дэд бүтцийг бий болгож, судалгааны лаборатори, материаллаг орчныг бэхжүүлэх замаар улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжилд хувь нэмэр оруулна;
- 8.2.3.6 Багш, судлаач, оюутан, зохион бүтээгчдийн шинэ технологи нэвтрүүлэх, дамжуулах, зохион бүтээх үйл ажиллагааг дэмжих, урамшуулах тогтолцоог бий болгоно.

ЕС. ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

9.1 Бодлогыг 2020-2030 он хүртэл 10 жилийн хугацаанд дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ;

- Нэгдүгээр үе шат (2020-2022 он);
- Хоёрдугаар үе шат (2023-2025 он);
- Гуравдугаар үе шат (2026-2030 он).

9.2 Бодлогын хэрэгжилтийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр хэмжинэ.

№	Шалгуур үзүүлэлт	Холбогдох чиглэл	Хэрэгжүүлэх хугацаа		
			I үе шат	II үе шат	III үе шат
			2020-2022 он	2023-2025 он	2026-2030 он



1	Багш, судлаач, суралцагчдын сэтгэл ханамжийн түвшин	8.1	30%	40%	50%
2	Эрдмийн зэрэгтэй профессор багш нарын эзлэх хувь	8.1	38%	50%	70%
3	ШУТИС-д бүтэн цагаар ажиллах судлаачийн тоо /магистр, доктор, докторын дараах хөтөлбөрүүдийн хүрээнд/	8.1	10%	24%	45%
4	Судалгааны төсөл, грант авсан судлаачдын нийт багшид эзлэх хувь, %	8.1	0.6%	7%	10%
5	Нэг багшид оногдох олон улсын эрдэм шинжилгээний мэдээллийн санд бүртгэлтэй бүтээлийн тоо	8.1	0.6	5	7
6	Бүтээлийн хуулбарлалт шалгах программыг ашигласан байдал, %	8.1	0%	50%	100%
7	Олон улсын мэдээллийн санд бүртгэлтэй дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлийн тоо	8.1	1	3	5
8	Гадаад багшийн нийт үндсэн багшид эзлэх хувь, %	8.1; 8.2	0.03%	4%	6%
9	Нийт орлогод судалгаа, инновацийн орлогын эзлэх хувь, %	8.2	12%	40%	60%
10	Нийт зардалд судалгаа, инновацийн зардлын эзлэх хувь, %	8.2	8.2%	30%	50%
11	Гадаадад, дотоодод магадлан итгэмжлэгдсэн лабораторийн тоо	8.1	4	15	43
12	Судалгаа-инновацийг дэмжих нэгжийн тоо	8.1; 8.2	1	3	5
13	Венч сангаас авсан санхүүжилтийн хэмжээ, %	8.1; 8.2	0%	1.5%	3%
14	ШУТИС-ийн эзэмшилтэй оюуны өмчийн тоо	8.1; 8.2	12	30	50
15	Идэвхтэй патентын тоо (олон улсад/дотоодод)	8.1; 8.2	3	10	30
16	Бойжуулсан гарааны бизнесийн тоо	8.2	2	10	30
17	Бие даан гарсан компаний тоо	8.2	0	2	5
18	Лицензийн гэрээний тоо	8.2	0	6	10
19	Үйлдвэрлэлд нэвтэрсэн технологийн тоо	8.2	0	5	10

АРАВ. БУСАД

10.1 Бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах саналыг ШУТИС-ийн Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэн, Эрдмийн зөвлөлөөр шийдвэрлүүлнэ.